

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.1 Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 49.2 дахь хэсэгт заасны дагуу Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан холбоо “Үндэсний холбоо” гэх тодотголыг оноосон нэрд хэрэглэнэ.

1.2 Үндэсний холбоо нь дараах шаардлагыг хангасан байна:

1.2.1 Үндэсний холбоо нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэр, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байх;

1.2.2 Үндэсний холбооны үйл ажиллагаа нь хоршооллын мөн чанарт түшиглэсэн, хадгаламж, зээлийн хоршооны олон улсын зарчимд нийцсэн байх бөгөөд эдгээрийг дүрэмдээ тусгасан байх;

1.2.3 Үндэсний холбооны гишүүнчлэл нь Монгол Улсын бүс нутагт хамгийн өргөн хүрээг хамарсан нийслэл, орон нутгийн хадгаламж, зээлийн хоршоодын 50-иас доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх;

1.2.4 ХЗХ-дын холбоо нь үүсгэн байгуулагдсанаас хойш 2 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа тогтмол явуулж, туршлага хуримтлуулсан байх;

1.2.5 Монголын хоршооллын хөдөлгөөнийг дэмжин “Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо”-нд гишүүнээр элсэн хамтран ажилладаг байх;

1.2.6 Олон улсын болон бүсийн түвшний ижил төрлийн зорилго бүхий байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлж чадсан, тэдгээрт гишүүнчлэлтэй байх;

1.2.7 Хадгаламж, зээлийн хоршоодын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө боловсруулсан, хадгаламж, зээлийн хоршоодод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх техник хэрэгслийн болон боловсон хүчний чадавхитай байх;

1.2.8 Үндэсний холбоо нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан бүтэц, зохион байгуулалттай, чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх;

1.2.9. Үндэсний холбооны удирдлага нь хадгаламж, зээлийн хоршооны салбарт 3-аас доошгүй жил ажилласан байх.

1.3 Үндэсний холбоонд тавигдах шаардлага хангагдсан болохыг Хорооны шийдвэрээр тодорхойлж, Хадгаламж, зээлийн хоршооны тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.